


# 2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН УУР АМЬСГАЛЫН ТОЙМ

Манай орны 10 дугаар сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар  $-3^{\circ}\text{C}$  ( $48.2^{\circ}\text{F}$ ) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар  $+3.1^{\circ}\text{C}$  ( $53.8^{\circ}\text{F}$ ) –аас  $+12^{\circ}\text{C}$  ( $66.2^{\circ}\text{F}$ ), бусад нутгаар  $-3.1^{\circ}\text{C}$  –аас  $+3^{\circ}\text{C}$  ( $48.4^{\circ}\text{F}$  –аас  $53.6^{\circ}\text{F}$ ) дулаан байдаг байна.


Монгол орны хэмжээнд 10 дугаар сард ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 3.2 хувь нь ордог. Тус сард нутгийн төвийн, хойд болон зүүн хэсгээр 5.1-18 мм, бусад нутгаар 0.3-5 мм тунадас ордог байна.



**Зураг 1.** 1991-2020 оны 10 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны газарзүйн тархалт


2024 оны 10 дугаар сарын агаарын дундаж температур өмнөх жилээс  $-2.2^{\circ}\text{C}$ -аар хүйтэн, ОЖД-аас  $+1.6^{\circ}\text{C}$ -аар дулаан байсан ба 1940 оноос хойш тохиолдож байгаа 9 дэх дулаан сар болж өнгөрлөө. Сарын агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайлтыг авч үзэхэд (Зураг 2) нийт нутгийн дийлэнх буюу 82.9% нь дунджаас  $+1.0$ -ээс  $+3.0^{\circ}\text{C}$ -аар дулаан, 17.1% нь дунджийн орчим байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 11.9 мм хур тунадас орсон нь өмнөх жилээс  $+85.1\%$ -иар, ОЖД-аас  $+42.6\%$ -иар ахиу бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 12 дахь ахиу тунадастай сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 69.8% нь дунджаас ахиу, 9.3% нь дунджийн орчим, 20.9%-д дунджаас бага хур тунадас унасан байна.




**Зураг 2.** 2024 оны 10 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын оронзайн тархалт

Монгол орноор болон 4 бүсээр хуваан дунджилсан 10 дугаар сарын агаарын температурын хоногийн явцыг авч үзэхэд (Зураг 3) эхний 10 хоногт нийт нутгаар температурын хэлбэлзэл харьцангуй ихтэй байв. 2 дугаар 10 хоногийн дунд үеэс эхлэн төв болон зүүн зүгийн нутгаар, 3 дугаар 10 хоногийн эхэн үед нийт нутгаар ОЖД-аас  $-0.8^{\circ}\text{C}$  -аас  $-5.4^{\circ}\text{C}$  хүйтэн байсан бол бусад хугацаанд агаарын температур ОЖД-аас  $+0.1^{\circ}\text{C}$  -аас  $+9.4^{\circ}\text{C}$ -аар дулаан байлаа. Хур тунадасны хувьд 1 дүгээр 10 хоногийн дунд үед өмнө зүгийн нутгаар, 2 дугаар 10 хоногт баруун болон төвийн хэсгээр, 3 дугаар 10 хоногийн эхэнд өмнө болон зүүн зүгийн нутгаар харьцангуй ахиу хур тунадас оржээ.



**Зураг3.** Хоногийн агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Тус сард агаарын температурын үнэмлэхүй их утга Дорноговийн Замын-Үүдэд  $25.1^{\circ}\text{C}$ , үнэмлэхүй бага утга Завханы Отгон суманд  $-26.1^{\circ}\text{C}$  хүрчээ. Хөрсний температурын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Цагааннуур суманд  $44^{\circ}\text{C}$ , үнэмлэхүй бага утга Баянхонгорын Байдрагт  $-28^{\circ}\text{C}$  хүрч хүйтэрсэн. Хоногт хамгийн ихдээ Дундговийн Гурвансайханд 5-ны өдөр 33.4 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 967.1гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 766.1гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Өмнөговь аймгийн Цогт-Овоо суманд 31м/с хүрчээ.



**Зураг 5.** Тус сард ажиглагдсан экстремаль утгууд